



<https://journal.mnier.mn>

Санал болгож буй эшлэл:

Санжаабадам, С., Баясгалан, Э. (2025). Боловсролоор дамжуулж үзэн ядах үг хэллэгийг хувирган өөрчлөх нь. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, 30(1).

<https://doi.org/10.56380/mjer.v30.1.5>

**Боловсролоор дамжуулж үзэн ядах үг хэллэгийг хувирган
өөрчлөх нь**

Сэдийн Санжаабадам 

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

Эрдэбаатарын Баясгалан 

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Transforming hate speech through the education

Sanjaabadam Sed 

Mongolian National Institute for Educational Research

Bayasgalan Erdenebaatar 

Mongolian State University of Education

To cite this article:

Sanjaabadam, S., Bayasgalan, E. (2025). Transforming hate speech through the education. *Mongolian Journal of Educational Research*, 30(1). <https://doi.org/10.56380/mjer.v30.1.5>



Боловсролоор дамжуулж үзэн ядах үг хэллэгийг хувирган өөрчлөх нь

Сэдийн Санжаабадам, Эрдэнэбаатарын Баясгалан

Өгүүллийн мэдээлэл

ХУРААНГУЙ

Түүх:

Хүлээн авсан: 2025.01.15
Засаж сайжруулсан: 2025.04.14
Хэвлэхийг зөвшөөрсөн: 2025.5.12

Түлхүүр үг:

үзэн ядах үг хэллэг
боловсролын тогтолцоо
хувирган өөрчлөлт

Олон улсын бичиг баримтуудад үзэн ядах үг хэллэгийг боловсролын тогтолцоогоор дамжуулж хувирган өөрчлөх гэдэгт бусдын ялгаатай хэрэгцээнд хүндэтгэлтэй хандах, хүлээн зөвшөөрөх, насан туршдаа суралцах боломжийг дэмжих, багшийн мэдлэг, арга зүй, ур чадварыг хөгжүүлэх, боловсролын үйлчилгээний тэгш, хүртээмжийг нэмэгдүүлэх зэргийг хамруулан тусгаж байна.

Бүх төрлийн үл тэвчих, ялгаварлан гадуурхах, үзэн ядах, дарамт шахалт үзүүлэх үг хэллэгээс хол байх зарчмыг хэрхэн баримтлах, эдгээртэй холбоотой бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга замыг судлах хэрэгцээ байгааг тодруулав.

Бодлого боловсруулагчдад сургалтын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, багшийн боловсрол, боловсролын байгууллагын удирдлага, манлайлал, хамтын ажиллагаа зэрэгт чиглэсэн цогц стратегиар дамжуулан үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх, зорилтот бүлэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар тодорхой шийдлийг санал болголоо.



Энэхүү өгүүлэл нь Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 Олон улсын лицензээр хамгаалагдсан болно

Холбоо барих зохиогч:

Эрдэнэбаатар Баясгалан
Монгол Улсын Боловсролын Их Сургууль
Email: bayasgalan2025@gmail.com

Transforming hate speech through the education

Sanjaabadam Sed, Bayasgalan Erdenebaatar

Article information

ABSTRACT

Article history:

Received: Jan 15, 2025
Revised: Apr 14, 2025
Accepted: May 12, 2025

Keywords:

hate speech
education system
transformation

Transforming hate speech through the education system includes respecting and recognizing the different needs of others, promoting lifelong learning opportunities, developing teachers' knowledge, methods and skills, and improving equality and access to educational services. At the same time, we will adhere to the principle of avoiding all forms of intolerance, discrimination, hatred and offensive speech.

Policymakers are offered concrete solutions to combat hate speech and reduce its impact on target groups through comprehensive strategies focusing on pedagogy, curricula, textbooks, teacher training, management of educational institutions, leadership and cooperation.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.

Corresponding author:

Bayasgalan Erdenebaatar
Mongolian National University of Education
Email: bayasgalan2025@gmail.com

УДИРТГАЛ

Монгол улс хүн үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх нь ардчилсан нийгмийн суурь зарчим ба хүний эрх, эрх чөлөөний баталгаа хэмээн хүлээн зөвшөөрдөг. Монгол Улсын Үндсэн хуулийн 16.16-д “...үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх...” эрх чөлөөг хуульчилж, ардчилсан нийгмийн суурь зарчмыг тусгасан. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” хэмээн зааж, хүн бүр хуулийн өмнө адил тэгш эрхтэйг тунхагласан байдаг. Гэтэл хүмүүс дээрх хуулийн заалтыг зөрчсөн ялгаварлан гадуурхсан, эсхүл гүтгэж, доромжилсон, мөн хүчирхийлэлд уриалан дуудсан, дайрч давшилсан, нэр хоч өгсөн зэрэг үг хэллэг, биеийн хэлэмж гаргаж байгааг “үзэн ядах үг хэллэг”-т хамаатуулан ойлгож болохоор байна. Үндсэн хууль болон Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудад үзэн ядах үг хэллэгийг ялгаварлан гадуурхал, гүтгэлэг, доромжлол гэдэг утгаар хэрэглэсэн байна.

Үзэн ядах үг хэллэг нь хүн төрөлхтөнд олон зуун жил дамнасан зүйл боловч дижитал технологийн тусламжтайгаар хувь хүн, нийгмийн бүлгүүдэд чиглэсэн үзэн ядалтын үг хэллэгийн тархалт, нөлөөлөл нь асар хурдтай нэмэгдэж байгаа тул уг асуудлыг анхаарах байдал ч нэмэгдэж байгаа юм. Иймээс “Hate speech” буюу үзэн ядах үг хэллэг нь даяарчлагдаж, ирээдүйн төлөв байдал тодорхойгүй, таамаглахад бэрхтэй, тогтворгүй, ээдрээтэй өнөөгийн нийгэмд тулгамдаж буй асуудлын нэг болж, онцгойлон авч үзэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Үүгээр зогсохгүй бидэнд Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх, эрх чөлөөний баталгаа зөрчигдөж байна (УИХ, 1992). Монгол Улсын даган мөрдөж байгаа Тогтвортой хөгжлийн зорилтыг биелүүлэхэд ч саад учруулж байна. Үзэн ядах үг хэллэгтэй тэмцэхтэй холбоотой НҮБ-аас зөвлөмж, уриалга, тунхаглал гарсаар байна (UNESCO, 2024). Түүнчлэн энэ асуудлын хүрээнд БШУЯ, БСҮХ хамтран “Монголын боловсролын хувирган өөрчлөлт” үндэсний чуулганыг олон талын оролцоотойгоор зохион байгуулж, нийгмийн бүлгүүдийн төлөөллийн зөвшилцлөөр “Монголын боловсролын тунхаглал 2024” хэмээх тунхаг бичиг гаргасан (Итгэл, 2024). Энэхүү тунхаг бичигт ёс зүйтэй иргэний асуудал чухалчлагдан тусав.

Боловсролын тогтолцоогоор дамжуулж хүн бүр сурч боловсрох, судлаач, эрдэмтэн, багш, иргэн бүр үзэл бодлоо илэрхийлэх академик эрх чөлөөтэй байж, хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх, төрт ёс, өв соёлоо дээдлэх, хүмүүсийн эв эетэй харилцааг бэхжүүлэх, хүн төрөлхтний нийтлэг соёлыг хүндэтгэх, ардчилсан, хүмүүнлэг, иргэний нийгмийг цогцлоох (БШУЯ, 2022), өөрийн үүрэг хариуцлагаа ухамсарладаг хариуцлагатай иргэн болж төлөвших, хувь хүний хөгжлийг дэмжихэд туслах (Итгэл ба бусад, 2024) улс орныхоо аюулгүй байдал, хөгжлийн бодлогыг нэгж хамт олон, салбар, орон нутаг, улсын хэмжээнд төлөвлөн хэрэгжүүлж, үндэстнээ манлайлан хөтлөх удирдагчдыг төлөвшүүлэх (Бэгз, 2023) зэрэг нь чухал байна. Үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх гэдэг нь дээр дурдсан зорилгын төлөөх үйл ажиллагаа юм.

Энэхүү өгүүллээр бид боловсролын байгууллагын бодлого боловсруулагчдад хандан үзэн ядах үг хэллэгийг боловсролоор дамжуулан хэрхэн хувирган өөрчилж, ёс суртахуунтай, үндэс язгуур, төрт ёс, өв соёлоо дээдэлсэн, үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэсэн, эрдэм боловсролтой, эх оронч, оюунлаг, бүтээлч дэлхийн иргэн бий болгоход зарим арга зам, шийдлийг санал болгож байгаа юм. Үүний тулд үзэн ядах үг хэллэгтэй холбоотой практик судалгааг хийхийн чухлыг гарган тавьж байна.

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Хэл нь хүний бий болгосон соёлын чухал хэсэг юм. Хэл бол хүн анх амьтны сүргээс тасарч, нийгмийн зохион байгуулалтаар амьдарч эхлэх үеийнх нь хөгжлийн үр дүн, нийгмийн хөгжлийн явцад үүсэж бий болсон харилцааны хэрэгсэл бөгөөд хүн даган дуурайх замаар сурч эзэмшдэг гэсэн байр суурийг баримталдаг эрдэмтэд давамгайлах хандлагатай байна. Хэл бол хүн амьдралын орчноо тэмдэглэх дохионы системийг бий болгосны үр дүн тул орчны өөрчлөлт, хөгжлийг тусгаж, тэдгээр ухагдахууныг тэмдэглэх нэгж болсон үгийн сан нь байнга өөрчлөгдөн баяжиж байдаг бас ядуурч ч болдог (Бэгз, 2023). Энэхүү үзэл баримтлалаар авч үзвэл, үзэн ядах үг хэллэгийг сурч болдог, хэрэглэхгүй бол бас мартаж болдог.

Үзэн ядах үг хэллэг нь хүний үйл илэрхийлэл, ёс суртахууны төлөвшилтэй уялдаатай тайлбарлагдах категори тул энэ чиглэлийн асуудлыг судлахдаа бид боловсрол, суралцахуйн

зорилго, иргэн төлөвших нийгмийн орчин, тухайн чиглэлээрх эрх зүйн орчныг авч үзэх шаардлагатай болж байна. Даяарчлал дангаарчлалын харилцан уялдаанд хөгжин буй өнөөгийн цаг үед монгол улс тэр тусмаа монгол хүн ямар онцлогтой болох түүний хөгжлийг хэрхэн дэмжих талаар хэлэлцүүлэг өргөн хүрээтэй явагдаж байна.

Монгол хүний зан төлөвийн онцлогийг түүний амин чанартай холбож тайлбарлах, уг гарвал шинжийг мөнхийн мэт тайлбарлах хандлага ч зарим эрдэмтэд, уран бүтээлчдийн хүрээнд байна. Энэ нь тухайн асуудалд олны анхаарлыг хандуулж байгаагаараа практик ач холбогдолтой.

Монгол хүндээ буй сайн, саар шинжүүд буюу харанхуй бурангуй, хэрцгий догшин авир, тэнэг мунхаг, омгорхог худалч бардам, атгаг сэтгэл, хүндлэлийг үл мэдэх, эв нэгдэлгүй, явдал нь бодлогогүй болхи зэргийг нь тодорхой гаргаж, түүнийг засаж сайжруулах санааг дэвшүүлэн тавьсан байдаг (Бэгз, 2024).

Тэгвэл монгол хүний зан төлөвийн эдгээр шинжийг саармагжуулах, эерэг шинжийг төлөвшүүлэх нөхцөлийг сайжруулах гэдэг нь сургууль, сургалтын тогтолцоотой уялдах нь гарцаагүй. Тиймээс үзэн ядах үг хэллэгтэй тэмцэж хувирган өөрчилж байгаа улс орнуудын судалгаа, баримталж буй бодлого, үзэл санаанаас авч үзье.

Үзэн ядах үг хэллэгтэй холбоотой асуудал, түүнтэй тэмцэх арга хэмжээ нь улс орнуудад өөр өөрийн онцлогтой байна. Испани улсын зарим судлаачид үзэн ядах үг хэллэгтэй холбоотой үг хэллэгийг хуульд тусган хязгаарлах нь хамгийн зөв арга гэж үздэг (Castellví, 2022). Үзэн ядах үг хэллэг нь үг хэлэх эрх чөлөө, нийгмийн сайн сайхан байдалд сөрөг нөлөө үзүүлдэг учир хуулиар хориглох нь зүйтэй гэж үздэг хэдий ч Parekh-ийн үзэж байгаагаар түүнийг дан ганц хуулиар хориглоод зогсохгүй боловсролын системээр дамжуулан түүнтэй тэмцэх нь илүү үр дүнтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн (Parekh, 2006). Харин Ирланд улсын судлаачид өөр өнцгөөс асуудлыг харсан. Mouffe (2000, 2005), Davies (2004, 2008, 2014) and Zembylas (2019) зэрэг эрдэмтэн судлаачид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх орчин бий болгох шаардлагатай гэж үзсэн (Pálmadóttir, 2018). Герман улсын хувьд үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх стратегийг тодорхойлох найдвартай, тохирц байдал хангагдсан асуумжаар (HITS) судалгаа хийжээ. Хоёр улсын багш нарын судалгаанаас харахад, тэд үзэн ядах үг хэллэгт өртсөн суралцагчидтай тулж ажилладаг байна. Харин боловсролын байгууллагын оролцогч талууд буюу багш, ажилтны үүрэг оролцоо сул байдаг юм байна. Үүнээс дүгнэхэд сургуулийн бие даасан байдал болон бүх багш, ажилтан хамтаараа үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх хэрэгтэй ба уг үйл ажиллагаанд оролцогч багш, бусад талын өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх нь үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх эхний чухал алхам гэдгийг судалгааны үр дүнд онцолсон байна (Bilz, 2024).

Эдгээр судалгаанаас харахад үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх үйл ажиллагаа нь сургууль дээр төвлөрөхдөө хамтын оролцоонд суурилсан өөрөөр хэлбэл суралцагчтай харилцагч бүхий л талуудын үүргийг эрхэмлэсэн нь онцлог байгаа юм.

Үзэн ядах үг хэллэг бол зөвхөн илрэл, нийгэмд гүн гүнзгий шингэсэн үл тэвчих, явцуу үзлийн илэрхийлэл хэмээн ЮНЕСКО үзэж байна. Тиймээс үзэл бодлоо илэрхийлэх, эрх чөлөөг хязгаарлах зэрэг хуулийн арга хэмжээ нь дангаараа хангалтгүй хэмээн үздэг судлаачийнхаар эсрэг, тэсрэг үзэл санаа, мэтгэлцээн, мөргөлдөөнөөс зайлсхийхгүйгээр харин энэ хүчийг улс, нийгэмдээ хэрэгтэй зөв урсгал болгон хувиргаж, өөрийн үүрэг хариуцлагаа ухамсарладаг хариуцлагатай иргэн болоход дэмжлэг үзүүлэх шаардлагатай гэж үзсэн байна (Mouffe, 2000).

Залуу эрдэмтэн судлаач, багш, шинээр ажилд орогч нарт тулгамдаж буй асуудал, санаа зовниж буй мэдрэмжээ нээлттэй ярилцаж, хэлэлцэж чадах тийм орчныг бүрдүүлж өгөх шаардлагатай. Үг хэлэх эрх чөлөөг хорьсноор түүнээс илүү муу үр дагаварт хүрч болзошгүй (Devis, 2004, 2008).

Иймээс асуудлыг цогцоор харж, шийдэхийн тулд хүмүүсийг боловсролоор дамжуулж соён гэгээрүүлэх, сэтгэлгээг нь өөрчлөх, аливааг харах өнцгийг нь тэлэх, хэлэлцүүлэг өрнүүлэх, бусдын ялгаатай байдалд хүлцэнгүй хандах, хүлээн зөвшөөрөх, ойлгодог болох талаас нь чиглүүлж түүнээс гадна төр нь үг хэлэх эрх чөлөөг хамгаалах эрх зүйн орчныг бэхжүүлэх шаардлагатай байна.

Үзэн ядах үг хэллэгтэй тэмцэхийн тулд нээлттэй бодитой мэдээллийн орчныг бүрдүүлэхтэй холбоотой санаа улс орнуудын хийсэн судалгаа болон энэ чиглэлээр ажиллаж буй судлаачдын бичвэрээс анзаарагдаж байна. Бусдыг хүлээн зөвшөөрөх, бодит баримтад тулгуурласан мэтгэлцээнийг өрнүүлэх, нээлттэй харилцах чадварыг хөгжүүлэх зэргийг онцлосон нь анхаарал татаж байна.

ҮНДСЭН АГУУЛГА

Үзэн ядах үг хэллэгийг тодорхойлох нь:

Үзэн ядсан үг хэллэгийг нэр томъёоны хувьд албан ёсны, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт хараахан гараагүй бөгөөд "үзэн ядах үг хэллэг" нь маргаантай, шийдэхэд бэрх, дийлэнхдээ сэтгэл хөдлөлийн шинжтэй, хувь хүний үзэл бодол давамгайлсан байдаг тул үүний эсрэг хариу арга хэмжээ авч тэмцэхэд ихээхэн асуудалтай тулгардаг. Учир нь бид юутай тэмцэж байгаагаа тодорхойлсны үндсэн дээр асуудлыг шийдэх нь зүйтэй. Тиймээс НҮБ нь үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх үйл ажиллагааны стратеги, төлөвлөгөө боловсруулж, "үзэн ядах үг хэллэг"-ийг дараах байдлаар тодорхойлсон байна. Хүний ялгаатай хэрэгцээ (УИХ, 2024) (хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендер, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээ)-ээс хамаарч хувь хүн болон бүлэг хүнд гаргаж буй хандлага, харилцаа нь ялгаварлан гадуурхах, гүтгэх, доромжлох, хүчирхийлэлд уриалан дуудсан, дайрч давшилсан, нэр хоч өгсөн зэрэг бүх төрлийн үг хэллэг, биеийн хэлэмж, зан байдлыг агуулсан бол "үзэн ядах үг хэллэг" гэж үзнэ гэж заасан байна.

Үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх үйл ажиллагаа нь хууль, дүрэм, журмын хүрээнд явагддаг. Ихэнхдээ цахим орчин дахь контент устгах, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг хянах, хүний нэр төр, алдар хүндийг санаатай гутаасан тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэх (УИХ, 2002), бусдын эрх чөлөө, нэр хүндэд харшлах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн захиалга, олон нийтийн эрүүл мэнд, ёс зүй гэсэн агуулгыг зөрчсөн тохиолдолд үгээ хэлэх эрх чөлөөг хязгаарлах (Тоби, 2013) зэрэг зохицуулалтын хүрээнд авч үздэг.

Түүнчлэн МУБИС-ийн ректор, профессор Ж.Батбаатар нь үзэн ядалтын хүрээ хязгаарыг тогтоох зайлшгүй шаардлагатай байна гэж үзжээ. Үзэн ядах гэдэг үг хэллэгт юуг авч үзэх вэ гэдгийг маш тодорхой тогтоох хэрэгтэй. Тэрээр үзэн ядах үг хэллэг гэдэг нь ерөнхийдөө ялгаварлан гадуурхал гэдэг рүү дөхөж очдог, туйлын шинж чанартай үг тул ихэвчлэн үндэстэн ястан, язгуур чанартай холбоотой болчих гээд байдгийг анхаарах хэрэгтэй гэж хэлсэн байна (ФЭС, 2018).

ЮНЕСКО-ийн сургагч багш нарт зориулан бэлтгэсэн гарын авлагад үзэн ядах үг хэллэгийг тодорхойлсон хэд хэдэн нэр томъёог авч үзье.

Хуурамч мэдээлэл (Disinformation) нь хувь хүн, нийгмийн бүлэг, байгууллага, улс оронд хор хохирол учруулахын тулд урьдчилан төлөвлөж зохиосон худал мэдээлэл юм. Энэ нь олон нийтийг төөрөгдөлд оруулж өөрийн мэдэлгүй худал мэдээ тараахад хүргэдэг.

Дэгс мэдээлэл (Malinformation) нь баримтад үндэслэсэн боловч хувь хүн, нийгмийн бүлэг, байгууллага эсвэл улс оронд хор хохирол учруулах, залилан мэхлэх зорилгоор анхны агуулгаас хазайсан мэдээлэл юм.

Таашаа мэдээлэл (Misinformation)- хувь хүн, нийгмийн бүлгүүд, байгууллага нь улс оронд хор хохирол учруулах, хууран мэхлэх санаа зорилго агуулаагүй хуваалцсан худал мэдээлэл (Нээлттэй нийгэм форум, 2021).

Суртал ухуулга (Propaganda)- хувь хүн, нийгмийн бүлэг, байгууллага нь улс төр, үзэл суртлын тодорхой үзэл баримтлалыг хүмүүст тулгах, нөлөөлөх, тэднийг ятгах зорилгоор ашигладаг худал, өрөөсгөл, төөрөгдүүлсэн мэдээлэл тараахыг хэлнэ.

Тэгэхээр үзэн ядах үг хэллэг гэсэн үгийг өөрт танигдах утгаар нь авч хэрэглэх нь судлаачийг төөрөгдөлд оруулж болзошгүй юм. Иймээс түүний утгыг илтгэх бүрэлдэхүүн, тэдгээрийн онцлогийг мэдэж тухай бүрд хамаарах агуулгыг авч үзэх хэрэгтэй.

Үзэн ядах үг хэллэгийн зорилго ба үр дагавар:

Үзэн ядах үг хэллэг нь хүн ам, зорилтот бүлгийн гишүүдийг туйлшруулах, хагалан бутаргах, дайсагналцуулах, айлган сүрдүүлэх гэх мэт янз бүрийн шалтгаанаар санаатай тархдаг. Эдгээр нь боловсролын түвшин, нийгэмд гарч буй аливаа ялгаварлан гадуурхалт, жендэр, шашин шүтлэг, байршлын ялгаанаас үүдэлтэй хувь хүн, бүлэг хүмүүсийг ялгаварлан гадуурхах мөргөлдөөн, дайсагналаас үүдэлтэй байж болно. Үзэн ядах үг хэллэгийн үр дагавар нь үүнийг хэн тарааж байгаа эсвэл юуг эсэргүүцэн тэмцэлдэж буйгаас хамаарч өөр өөр үр дүнд хүрж болно. Үзэн ядах үг хэллэг нь дэлхий даяар үйлдэгдэж буй бүх төрлийн харгис хэрцгий үйлдэл болох шашин шүтлэг, гарал үүсэлтэй холбоотой хүмүүсийг үй олноор нь хоморголон устгах, аймаглан устгах гэх мэт хүчирхийллийн бүх төрлийн хэлбэрийг бий болгох хүчин зүйлийн нэг нь болсоор ирсэн.

Үзэн ядсан үг хэллэгийн үр дагавар нь эрх мэдлийн хөдлөл зүйгээс хамаардаг. Тухайлбал үзэн ядах үг хэллэг тухайн сургуулийн орчинд нэмэгдэж байхад сургуулийн захирал, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч болон бусад боловсролын байгууллагын гишүүд нь чимээгүй өнгөрч, хайхрамжгүй хандвал үзэн ядах үг хэллэг хүчээ авах орчин нөхцөл бүрдэнэ. Зарим тохиолдолд эдгээр хүмүүс гал дээр тос нэмж үзэн ядах үг хэллэгийн галыг улам асаадаг байна. Үзэн ядах үг хэллэгт хариу өгөхдөө ямар зорилгод хүрэх, ямар үр дагавар гарахыг тооцоолж, хариу арга хэмжээ авах шаардлагатай.

Үзэн ядах үг хэллэгийг боловсролоор дамжуулж хувирган өөрчлөх нь:

Үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх үйл ажиллагаа нь хууль, дүрэм, журмын хүрээнд явагдана. Ихэвчлэн цахим орчин дахь контент устгах, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг хянах, нэр төр, алдар хүндийг санаатай гутаасан тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэх (УИХ, 2002), бусдын эрх чөлөө, нэр хүндэд харшлах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн захиалга, олон нийтийн эрүүл мэнд, ёс зүй гэсэн агуулгыг зөрчсөн тохиолдолд үгээ хэлэх эрх чөлөөг хязгаарлах (Тоби, 2013) зэрэг зохицуулалтын хүрээнд тэмцэх үйл ажиллагааг авч үздэг.

Солонгос, Герман, Их Британи, Австрали гэх мэт улс нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу хүүхдийг цахим орчны сөрөг агуулга, үг хэллэгтэй контентоос хамгаалах, тэдгээрийн хандалтыг хязгаарлах, арилгах зэрэг технологийн зохицуулалт хийх чиглэлээр ихэвчлэн тухайн орны харилцаа холбооны газрууддаа үүрэг болгодог (Харилцаа холбооны зохицуулах хороо, 2021) ч үгээ хэлэх эрх чөлөө болон үзэн ядах үг хэллэгийг хэрхэн зохицуулах стратегийн хэрэгжилт, хууль эрх зүйн орчин, бодлогын хувьд улс орнуудад үзэл бодлын ялгаа гарч, тэдний тулгамдсан асуудлын нэг болж байна.

Үзэн ядах үг хэллэг, тэдгээрийг хүч хэрэглэн таслан зогсоох зохицуулалтын стратегийн хүрээнд богино хугацаанд асуудлыг түргэн шуурхай шийдэж байгаа тухайн хууль, журам нь зарим улс орнуудын ардчиллын үзэл санаа, үгээ хэлэх эрх чөлөө болон хүний эрхэд халдаж, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцтэй зөрчилдөж байна.

Үзэн ядах үг хэллэг нь аюултай, тэгш бус, ялгаварлан гадуурхагдсан суралцах орчныг бий болгодог сөрөг нөлөөтэй. Сургуулийн орчин дахь үзэн ядалт нь олон хэлбэрээр илэрдэг. Тухайлбал, багш-багш, багш-сурагч, сурагч-сурагчийн хооронд болон хичээлийн, хичээлээс гадуурх үйл ажиллагааны үед гэх мэт албан болон албан бус сургалтын орчинд илэрдэг. Боловсролын салбар үзэн ядах үг хэллэгтэй тэмцэн урьдчилан сэргийлэх, бууруулах, асуудлыг дангаараа даван туулна гэдэг нь өрөөсгөл юм. Харин энэхүү асуудлыг шийдэхийн тулд өргөн хүрээтэй, харилцан зөвшилцөл, хамтын ажиллагаа, олон салбарын оролцоог хангасан үр дүнтэй арга замыг хайх нь чухал билээ.

Хохирогчийг цахим, цахим бус орчин, өөрт нь болон олон нийтийн газарт үзэн ядсан үг хэллэг ашиглан гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, хүчирхийлэх, заналхийлэх, олон нийт түүнийг өөгшүүлэх зэрэг олон хэлбэрээр хохироож болзошгүй. Эдгээр нь нийгмийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалтыг улам хурцатгадаг. Үзэн ядсан үг хэллэг нь хурцадмал байдал, мөргөлдөөнийг үүсгэх, онцгой байдлын үед онц аюултай байдал бий болгох зэрэг эрсдэл үүсгэж болох юм. Энэ нь хүчирхийллийг хэт өөгшүүлэн бусдыг үзэн ядах сэдлийг өдөөж, гэмт хэрэг болон бусад харгис хэрцгий үйлдлүүдийг гаргах өдөөгч нь болдог.

Энэ асуудлыг шийдэхийн тулд боловсрол үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх стратегийн зайлшгүй нэг хэсэг болж, энэ нь үзэн ядах үг хэллэгийг хүлээн авахаас зайлсхийсэн, хүмүүнлэг, тэсвэртэй, хүний эрхийг дээдэлсэн, аливаа асуудлыг энх тайвнаар шийддэг, тэгш хүртээмжтэй нийгмийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн хувь хүний хөгжлийн урт хугацааны томоохон хөрөнгө оруулалтыг уриалах юм.

Боловсролын хариу арга хэмжээг бэхжүүлэхийн тулд ялгаварлан гадуурхалтад өртдөггүй, үзэн ядах үг хэллэгийн нөлөөнд автдаггүй, тухайн үг хэллэгийг түгээн дэлгэрүүлэх магадлал бага, суралцагчдыг сурч боловсрох, хүмүүжих уян хатан орчныг бий болгох шаардлагатай. Энэ нь боловсролын нийгэм, соёл, ёс суртахуун, хүмүүнлэгийн зорилгыг агуулсан Тогтвортой хөгжлийн зорилт 4.7-д хүрэх хүчин чармайлт, “Боловсрол-2030” хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол цөм нь юм.

Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилтын хүрээнд хүний эрхийг дээдэлсэн, харилцан ойлголцолд тулгуурлан хүмүүнлэг, хүртээмжтэй, тэгш чанартай боловсрол эзэмших, хүн бүрийн насан туршдаа суралцах боломжийг хөхиүлэн дэмжих гэж заасан байдаг. Түүнчлэн үзэн ядах үг хэллэгийг эсэргүүцэх нь энх тайван, хүний эрх (зорилт 4.7)-ийн боловсрол, бүх нийтийн соёлын

боловсрол, бүх төрлийн боловсролоор дамжуулан хүчирхийлэлтэй өнгөрсөн үеийн алдаа болох гарал үүслээс улбаатай үй олноор нь хоморголон устгах, аймаглан устгах гэх мэт хүчирхийллийн бүх төрлийн хэлбэр, үзэн ядах үг хэллэгээс урьдчилан сэргийлэх, түүнийг залруулах, соён гэгээрүүлэх, хуулиа дээдлэх ёсыг бэхжүүлэх зэрэг олон талт, нэгдсэн арга барилыг шаарддаг.

Боловсролоор дамжуулан үзэн ядах үг хэллэгтэй тэмцэнэ гэдэг нь хүний эрх, соёлын олон төрөл, зүйл, итгэл үнэмшил, арьс өнгө, шашин шүтлэг, жендэр, бэлгийн чиг хандлага зэрэг ялгаатай байдлыг хүндэтгэсэн, хүлээн зөвшөөрсөн, дэмжсэн аюулгүй, хүртээмжтэй, үзэн ядалтгүй сургалтын орчныг бүрдүүлэхийн тулд боловсролын байгууллага болон салбарын багш, ажилчдын чадавхыг бэхжүүлэхийг хэлнэ. Энэ нь бүх төрлийн хүчирхийлэл, доромжлол, үл тэвчих байдал, үзэн ядалттай идэвхтэй тэмцэж, шударга ёс, тэгш байдлыг тогтоох арга барилыг шаардахаас гадна бүх насны суралцагчдыг харгислал, хэрцгийлэл, гэмт хэрэгт турхирсан, зөрчил, мөргөлдөөн, хүчирхийлэл зэргийг өдөөсөн, дэмжсэн, үзэн ядалтын суртал ухуулга, хэт туйлширсан үг хэллэгийн үр дагавар, үр нөлөө, бие махбодын хүчирхийлэл болон үзэн ядах үг хэллэгийн хоорондын холбоо хамаарал, хор уршгийг таньж мэдэх, хэрхэн тэмцэх стратегийг дотроо багтаадаг.

Мөн стратегид суралцагчид үзэн ядсан үг хэллэг агуулсан мэдээ мэдээлэл, суртал ухуулгыг таньж мэдэх, түүнээс зайгаа барих, няцаахын тулд шүүн тунгаах сэтгэлгээ бүхий мэдлэг, ур чадвар, хандлагатай, соёлын олон төрөл, ялгаа, онцлогтой хүмүүсийг хүлээн зөвшөөрч, харилцан ярих чадвартай болоход нь туслах зэрэг орно. Түүнчлэн суралцагчийг цахим орчинд аюулгүй, хариуцлагатай байх боломжийг өгч, үзэн ядах үг хэллэгт тэсвэртэй байх чадварыг хөгжүүлэх хэрэгтэй.

Иргэн хүн бүр хүлээн зөвшөөрөгдсөн, хүндлэгдсэн, бие биеэ хүндэтгэсэн, зорилготой, бусадтай хүлээцтэй, энэрэнгүй, тэвчээртэй харилцдаг, эмпати чадвартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй нийгэмд амьдрах, суралцах нь эцсийн гол зорилго юм.

Үзэн ядах үг хэллэг ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө:

Боловсролоор дамжуулж үзэн ядсан үг хэллэгийг хувирган өөрчлөхдөө үгээ хэлэх эрх чөлөө, түүнийг дэмжих, хамгаалах нь нэн чухал билээ. НҮБ нь “боловсрол”-ыг үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх нэг зэвсэг гэж тодотгож хэлсэн (UNESCO, 2024). Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүний эрхийн түгээмэл тунхаглал зэрэг бусад хүний эрхтэй холбоотой олон улсын конвенц, Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг хамгаалахаас үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх нь илүү төвөгтэй, нарийн ажиллагаа шаарддаг.

Олон улсын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах стандартад хувь хүн, бүлэг хүнийг доромжилсон, тайван байдлыг алдагдуулсан, нэр хүндийг гутаасан, цочролд оруулсан үг хэллэг хамаардаг боловч хохирогч /хувь хүн, бүлэг хүн/-ийн хэлсэн үгээр хуулийн хариуцлага хүлээлгэдэггүй.

Монгол Улсын Үндсэн хуулиар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх чөлөөг олгосон ч үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх нь манай оронд тулгамдаж буй асуудлын нэг болоод байна. Тиймээс үзэн ядах үг хэллэгийг хувирган өөрчлөхийн зэрэгцээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг дэмжихэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага харагдаж байна. Учир нь үзэн ядах үг хэллэгийг хязгаарлахад хүний үг хэлэх эрх чөлөөнд хязгаарлалт үүсэх эрсдэлтэй. Энэ асуудлыг ч судлаачид онцолж байна. Тэгвэл үзэн ядах үг хэллэгтэй хэрхэн тэмцэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хийгээд үзэн ядах үг хэллэгийн түгээн дэлгэрэх байдлын харилцан уялдааг ямар бодлого, стратегийг зохицуулах тухай бид холбогдох судалгааг хийх шаардлагатай болжээ.

Бусад улсын туршлагаас харахад, зарим багш нар үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, үзэн ядах үг хэллэгтэй хэрхэн тэмцэх, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар арга барилаа олдоггүй байна. Ийм тохиолдолд сургуулийн менежмент, сургалтын хөтөлбөрийн болон хүүхэд хөгжлийн бодлогын хэрэгжилт улмаар багшийн хөгжлийн чиглэлээр хэрэгжиж буй үйл ажиллагаанд бид уг асуудлыг хэрхэн тусгаж авч явахгаа тооцох цаг тулсан байна.

Монголчуудын гэрийн хүмүүжил боловсрол нь нэгд, ажил хөдөлмөрийн мэдлэг, дадлагатай болгож, хожим амьдралаа өөрөө бие даан авч явах чадвартай болгох, хоёрт, эрүүл мэндээ

хамгаалахын зэрэгцээ гэр бүл зохиож, үр хүүхдээ эрүүл энх өсгөн бойжуулах, гуравд, нийгэм дотор биеэ зөв авч явж, бусадтай харилцаж, хамтран аж төрөх чадвартай болж нийгмийн харилцаанд ороход бэлтгэдэг байна (Цанжид, 2024).

Бусдад хандсан үзэн ядах үг хэллэгийг цахим болон цахим бус орчинд хязгаарласнаар боловсролын салбарын бодлого боловсруулагчид, ажилтан, багш нар болон суралцагчдын өөртөө итгэх итгэл нэмэгдэн, өөрийгөө үнэлэх үнэлэмж нь дээшилж, үзэл бодлоо аюулгүй, тайван арга замаар илэрхийлэх эрүүл, аюулгүй орчин бүрдэх юм. Иймээс үзэн ядах үг хэллэгт “цензур” тогтоох нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгож буй нэг илрэл юм. Суралцах явцдаа эзэмших томоохон чадваруудын нэг нь бусдын нэр төрд халдахгүй байх, үзэл бодлоо зөв боловсон илэрхийлэх, үзэн ядах үг хэрэглэхээс татгалзах явдал юм.

Хүнийг хүн болгодог, хүний мөн чанарыг тодорхойлогч гол шинжийн нэг бол хүнлэг ёс, хүн чанар юм. Монгол хүний хүнлэг хүн байх шинжид хүнийг хүн ёсоор үзэх, өөрийгөө болон бусдыг хүндэтгэх, хайрлах, халамж анхаарал тавих, бусдын санаа сэтгэлийг ойлгох, хүлээцтэй хандах, эелдэг эвсэг байх, хүн хүндээ найз нөхөр, ах дүү байх, хүн хүндээ туслах, өөрийн болон бусдын нэр төрийг хайрлах, бусдын төлөө гэх сэтгэлтэй байх, бусдыг алагчлах үзлээс ангид байх, хэт аминч үзлээс ангид байх, сэтгэлийн тэнхээтэй байх зэрэг чадвар хамаарна (Рэнчин & Дашдорж, 2024).

Учир нь үзэн ядах үг хэллэг нь бидний эрүүл, аюулгүй орчинд суралцахад саад болдгоос гадна хувь хүний аюулгүй байдалд заналхийлдэг. Тиймээс үг хэлэх эрх чөлөөг дэмжихийн зэрэгцээ үзэн ядах үг хэллэгийг хувирган өөрчлөх шаардлагатай байна.

Боловсролын үр өгөөж, үр нөлөөгөөр хувирган өөрчлөх нь:

Боловсролын байгууллага нь хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засгийн ялгаатай байдал, хаана байгаагаас үл хамааран бүгдэд ижил тэгш байх, Боловсролын ерөнхий хуулийг мөрдөх, сургалтын нэгдсэн хөтөлбөрийн дагуу хичээллэх, ижил агуулга бүхий сурах бичгийг ашиглах, нийтлэг үнэт зүйл, хэм хэмжээг сахин баримтлахад луужин болдог.

Улс орнуудын түүхэн замналыг харахад, төр засаг нь боловсролын тогтолцоог эсрэг үзэл суртал тараах, ухуулах, бусдаас өөрийгөө дөвийлгөх, өөрийгөө дээр гэж үзэх, зарим үндэстэн, ястныг үзэн ядахад хүргэхэд хөхиүлэн дэмжих зорилгоор сургалтын хөтөлбөр, заах арга барилд оролцоогоо нэмэгдүүлж, шахалт үзүүлэх, цензур тогтоох, идэвхтэй нөлөөлөх байдлаар буруу аргаар ашигласан гашуун туршлагауд байна. Тиймээс улс орны бодлого нь хаашаа чиглэж байгааг анхааралтай ажиглан, үзэн ядах үг хэллэг, ялгаварлан гадуурхалтаас хол, тэгш хүртээмжтэй боловсролын тогтолцоог бий болгоход анхаарлаа хандуулах шаардлагатай.

Боловсролын бодлого боловсруулагч, судлаач, сургуулийн удирдлага, менежер, багш, эцэг эхчүүдээс эхлээд сургуулийн үйлчлэгч, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтан, сургуулийн жижүүр гээд боловсролын байгууллагад ажиллаж буй хүн бүр хүүхэдтэй хэрхэн харилцаж, ямар хариу үйлдэл үзүүлж байгаагаас шалтгаалж, тэдний юу сурах, юу бодох, ямар үг хэллэг ашиглах, хэнтэй хэрхэн харилцах гэх мэт харилцааны соёл бүрэлдэн тогтдог. Суралцагчид эргэн тойронд нь ямар харилцаа үүсэж байгааг анхааралтай ажиглаж байдаг.

Учир нь монголчууд эртнээс нааш хүүхэд залуусаа эрдэм номд сургахаас дутуугүй тэднийг хүн болгон хүмүүжүүлэх боловсролын үүргийг чухалд үзэж ирсэн уламжлалтайг номыг нь сурахгүй ч номхоныг нь сурах талаар судар номд бичиж, ард түмэн олон үеэр хэлэлцэж ирснээс харж болно (Монгол ардын цэцэн үг, 1989). Дээр дурдсанаар, боловсролын нийгмийн үүргүүдийн хамгийн чухал ч гэж үзэж болохоор суралцагчдад шинжлэх ухааны мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэхээс дутуугүй тэднийг нийгмийн гишүүн, иргэн болгон хөгжүүлж төлөвшүүлэх үүрэг манайд энэ хугацааны боловсролын бодлогод ихээхэн үгүйлэгдэж буйг тэмдэглэх хэрэгтэй (Бэгз, 2024).

Сургууль дээр зохион байгуулж буй хичээлээс гадуурх арга хэмжээ болох баяр ёслол, спортын өдөрлөг, зугаалга ямар байх, асран хамгаалагчийн хуралд юу ярих, хичээлийн үеэр багш ямар үг

хэллэг ашиглах, ямар биеийн хэлэмж үзүүлэх, сургуулийн ажилтнууд хоорондоо хэрхэн харилцах болон сургуулийн нэр, уриа ямар үг, өнгө аястай байх, хүрэлцэн ирж буй зочин илтгэгч хэн байхаас шалтгаалаад тухайн сургууль эрх тэгш, эрүүл, аюулгүй орчныг бий болгох уу эсвэл эсрэгээрээ ялгаврлан гадуурхалт, тэгш бус байдал, үзэн ядах үг хэллэгийг урин дуудах уу гэдэг нь хамаарна. Учир нь сургууль бүр өөрийн гэсэн соёл, үнэт зүйлс, баримталж буй бие даасан бодлого, менежменттэй байдаг бөгөөд үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх, түүнийг хувирган өөрчлөхөд маш чухал оролцоотой билээ.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Үзэн ядах үг хэллэг маш хурдацтай, өргөн хүрээг хамран тархаж, хувь хүн, хэсэг бүлэг хүний эрхэд халдаж байгаа боловч манай улсад энэ талаар хийсэн судалгаа, үзэн ядах үг хэллэгийг тарааж түгээхийн эсрэг чиглэсэн ямар нэг ажил, санаачилга хангалтгүй байна. Тиймээс бид сүүлийн үед ЮНЕСКО-оос гарсан баримт бичиг, зөвлөмжид тулгуурлан онолын хэсгийг бичсэн болно. Иймд цаашид илүү нарийвчилсан судалгааны ажлыг хийж, боловсролын салбарт ажиллаж буй бодлого боловсруулагч, судлаач, багш, ажилтан, суралцагчийн үзэн ядах үг хэллэгийн талаарх хэвшмэл ойлголт, мэдлэгийг тандах, чиг хандлагыг тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах цогц стратеги шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Үзэн ядах үг хэллэгийг хувирган өөрчлөх гэдэг нь боловсролын салбарын илүү өргөн хүрээ, үйл ажиллагаагаар тодорхойлогдож, боловсролын салбарын багш, ажилтан зөвхөн хууль, эрх зүй, байгууллагын дотоод журмыг сахидаг төдийгүй ёс суртахуун, ёс зүйтэй, соёлын нийтлэг үнэт зүйлийг хүндэтгэсэн, дагаж мөрдөх эрхэм зорилгод нэгдэх шаардлага үүсээд байна. Түүнчлэн энэ хувирган өөрчлөлт нь зөвхөн сургалтын үйл явцад шийдэж болох энгийн асуудал биш, бие хүн болж төлөвших, бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, нийгмийн бүрэлдэхүүн хэсгийн нэг болохтой холбоотой боловсролын салбарын насан туршдаа суралцах нийгэмшүүлэх үйл явцын нэг бүрэлдэхүүн хэсэг ажээ.

Үзэн ядах үг хэллэгтэй холбоотой судлагдсан байдал, судалгааны ажил хийх хэрэгцээ үүсэж байна. Үзэн ядах үг хэллэгийг сургалтын хөтөлбөр, багшлах арга техникээр өөрчлөх гэсэн явцуу утгаар авч үзэх нь өрөөсгөл юм.

Зарим улс орон үзэн ядах үг хэллэгтэй холбоотой судалгаа хийж, судалгааны үр дүнд суурилсан бодлого боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Иймээс Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн судлаачдын баг үзэн ядах үг хэллэгийг илрүүлэх мөн тохирсон цогц стратеги, арга хэмжээ авахад нотолгоогоор хангах зорилгоор Герман улсад хэрэглэж байгаа тохирц найдвартай байдал нь хангагдсан Hate Speech Intervention Scale for Teachers олон улсын арга аргачлалыг монгол хэл дээр нутагшуулах, хэрэглэх боломжийг судалж байна.

ЗОХИОГЧДЫН ОРОЛЦОО (Times New Roman 11)

Онолын үндэс, санаа: С.Б., Э.Б; Арга зүй: С.Б.; Бичилт (эхний хувилбар): С.Б., Э.Б.; Бичилт (засвар): С.Б., Э.Б.; Нөөц: Э.Б; Мэргэжлийн удирдлага: С.Б.

НОМ ЗҮЙ

Bilz, L. F.-D. (2024). Teachers' intervention strategies for handling hate-speech incidents in schools.

Social Psychology of Education, 1-24. <https://doi.org/10.1007/s11218-024-09929-9>

Castellví, J. M.-V. (2022). Future teachers confronting extremism and hate speech. *Humanities and Social Sciences Communications*, 9(1), 1-9. <https://doi.org/10.1057/s41599-022-01222-4>

Pálmadóttir, J. A. (2018). Hate speech an overview and recommendations for combating it. *Icelandic Human Rights Centre*, 1-27.

Parekh, B. (2006). Hate speech. *Public policy research*, 12(4), 213-223. <https://doi.org/10.1111/j.1070-3535.2005.00405.x>

UNESCO. (2024). *Addressing hate speech through education. A guide for policy-makers*. Татаж авсан холбоос [Addressing hate speech through education: A guide for policy makers | UNESCO](#)

- БШУЯ, Б. (2022). *Хувьсаж буй боловсрол*” үндэсний хэлэлцүүлэг. УБ. Татаж авсан холбоос
<https://www.news.mn/mn/posts/48/24>
- Баярмаа, Б. (2020). Унгар улсын боловсролын тогтолцоо. *Боловсрол судлал (168)*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Бэгз, Н. (2023). Монголын боловсрол судлал. *Боловсрол судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Бэгз, Н. (2023). Хэл хүний бүтээл, соёл мөн. *Боловсролын судалгааны монголын сэтгүүл*, 28 (2).
<https://doi.org/10.56380/v28.2.1>
- Бэгз, Н. (2024). Боловсролын хөгжлийн философийг Монголд судлах хэрэгцээ, хэрэгжүүлэх үндэслэл. Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл.
<https://doi.org/10.56380/mjer.si.2024.02>
- Бэгз, Н. (2024). Монгол хүн гэж хэн бэ, түүний хөгжлийн философи үзэл санааг хэрхэн томъёолох вэ? *Боловсрол судлал сэтгүүл*, 204(6). Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Итгэл, М. (2024). Монголын боловсролын хөгжлийн философи үндэслэл. Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл. <https://doi.org/10.56380/mjer.si.2024.01>
- Итгэл, М., Отгонбаатар, Х., Санжаабадам, С., Туяа, У., Энхжаргал, Х., & Дэнсмаа, Ж. (2024). Монголын боловсролыг тогтвортой хөгжүүлэх үзэл санаа. Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл, 29(2). <https://doi.org/10.56380/mjer.v29.2.1>
- Нээлттэй нийгэм форум. (2021). “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик” илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал. Татаж авсан холбоос <https://forum.mn/product/211512>
- Рэнчин, Д., & Дашдорж, О. (2024). Монгол хүний мөн чанарын асуудалд. Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл. <https://doi.org/10.56380/mjer.si.2024.09>
- Тоби Мэндэл (2013). *ЮНЕСКО-н хэвлэл мэдээллийн шалгуур үзүүлэлтүүдийг хэрэглэх нь*. Хууль эрх зүй ба Ардчилал төв. Татаж авсан холбоос
<https://www.gic.mn/images/upld/MDITobyguidebookmonlast.pdf>
- УИХ. (1992). *Монгол улсын үндсэн хууль*. Татаж авсан холбоос
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
- УИХ. (2002). *Эрүүгийн хууль*. УБ: Монгол улсын хууль. Татаж авсан холбоос
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=12172>
- УИХ. (2024). *Боловсролын ерөнхий хууль*. Монгол Улсын хууль. Татаж авсан холбоос
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301>
- Цанжид, А. (2024). Монголчуудын сурган хүмүүжүүлэх ухааны уламжлал ба өнөө үе. Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл. <https://doi.org/10.56380/mjer.si.2024.03>
- Хэвлэл мэдээллийн зөвлөл (2018). *Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг контент анализын судалгаа*. Татаж авсан холбоос
https://resource4.sodonsolution.org/mediacouncil/File/2021/01/25/u289iidn0mjihuid/tsahim_saituud_dahi_uzen_yadaltiin_ug_helleg.pdf
- Харилцаа холбооны зохицуулах хороо. (2021). *Цахим орчны зохицуулалт зөвлөмж*. Татаж авсан холбоос
<https://crc.gov.mn/storage/1.2%20%D0%A6%D0%B0%D1%85%D0%B8%D0%BC%20%D0%BE%D1%80%D1%87%D0%BD%D1%8B%20%D0%B7%D3%A9%D0%B2%D0%BB%D3%A9%D0%BC%D0%B6.pdf>

Зохиогчдын мэдээлэл

Овог, нэр: Сэд Санжаабадам

 <https://orcid.org/0000-0002-9201-0358>

Байгууллагын нэр: БСҮХ

Хаяг: СБД, 8-р хороо, Энхтайваны өргөн чөлөө,
Багшийн хөгжлийн ордон, 3-р давхар

Улс: Монгол

e-mail: sanjaabadam@mnier.mn

Овог, нэр: Эрдэнэбаатар Баясгалан

 <https://orcid.org/0000-0003-2362-9074>

Байгууллагын нэр: МУБИС, БОСС, Сэтгэл
судлалын тэнхмийн докторант

Хаяг: СБД, 8-р хороо, Бага тойруу - 14

Улс: Монгол

e-mail: bayasgalan@mnier.mn